



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон нь Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2013 оны 15/03/013/122 дугаар актаар тогтоогдсон нийт 79,224,896.00/ далан есөн сая хоёр зуун хорин дөрвөн мянга найман зуун ерэн зургаан/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал Э.Хүдэрчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг эрүүл мэндийн байгууллагын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4.Авсан арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/ түүрэг болгосугай.

ДАРГА



3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Даргана

Д.НАРАНГЭРЭЛ

900250

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

Өвөрхангай аймаг дахь Бусийн оношилгоо, эмчилгээний төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлаж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Халдвартын барилга	1970	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	38,739,600.00	38,739,600.00	0
2	Бохирын худаг, Цооног	2011	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	12,482,000.00	12,482,000.00	0
3	Грааш	1961	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	8,675,000.00	15,120,000.00	0
4	Худгийн байшин	1961	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	2,095,600.00	2,095,600.00	0
5	Төмөр хашаа	2003	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	2,448,000.00	2,448,000.00	0

6	Хайс	2009	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	1,281,600.00	1,281,600.00	0
7	Төмөр хашаа	2004	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	13,475,712.00	13,475,712.00	0
8	Сандалп /модон 2 ширхэг/	1997	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Намнансурэнгийн гудамж	27,384.00	27,384.00	0
			Нийт дүн	79,224,896.00 <i>/далан есөн сая хоёр зуун хорин дөрвөн мянга найман зуун ерэн зургаан/</i>	79,224,896.00 <i>/далан есөн сая хоёр зуун хорин дөрвөн мянга найман зуун ерэн зургаан/</i>	0